



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/239

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн
авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 18,900,000.00 (арван найман сая есөн зуун мянга) төгрөгийн үнэ бүхий 11-94 УНП улсын дугаартай Киа бонго маркийн тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Энэ захирамжийн нэгд заасан тээврийн хэрэгслийг балансад бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Сүхбаатар дүүргийн “Сүхбаатар дэвшил менежмент” ААТҮГ (С.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110201216